

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛ-ТЕХНИКИЙН ХАНГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Г.Гантулга

*ХХЕГ-ын Техникийн хэлтсийн
дарга, докторант, хурандаа*

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд Улсын хил хамгаалалтын материал-техникийн хангалтын тогтолцоо, хангалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг талаар тусгасан болно. Үүнд: Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн материал-техникийн хангалтын тогтолцоо, Материал-техникийн хангалтын өнөөгийн байдал, Материал-техникийн хангалтын цаашдын чиг хандлагын талаар дурдсан болно.

Түлхүүр үгс: материал-техникийн хангалт, ар талын хангалт, оператив-стратег, тогтолцоо.

Удиртгал

*Зэвсэгт хүчний болон
Хилийн цэргийн материал-
техникийн хангалтын тогтолцоо*

Цэргийн түүхийг судлан үзэхэд, техник технологи сайжрах, шинээр нэвтрэх тутам томоохон зэвсэгт мөргөлдөөн, дайнд оролцогч талуудын цэргийн стратеги, оператив, тактикийн арга үйл ажиллагаанд шинэчлэл өөрчлөлт орж, түүнийг даган хангалтын тогтолцоог хөгжүүлэх

шаардлага урган гарснаар уг тогтолцоонд шинэчлэл хийгдэн дэвшил гарах хөгжлийн зүй тогтол хэрэгжиж иржээ.

Сүүлийн жишээ гэхэд ОХУ-ын Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд Украин улсын хилд цөмрөн зэвсэгт мөргөлдөөн эхэлж, уг зэвсэгт мөргөлдөөний үр дүнд материал-техникийн хангалт шууд нөлөөлж байгаа нь зэвсэгт мөргөлдөөн, дайнд материал хэрэгслийн хангалт чухал үүргийг гүйцэтгэдэг гэдэг ухагдахуун одоо ч утгаа алдаагүйг харуулсан томоохон жишээ болж байна.

Дэлхийн тэргүүлэх улс орнуудын цэргийн байгуулалтын туршлагаас үзэхэд зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн үйлдвэрлэл, нийлүүлэлт болон хангалтыг тус тусдаа байгууллага хариуцдаг тогтолцоотой байна. Зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг ОХУ-ын БХЯ-нд Зэвсэглэлийн газар, Германы БХЯ-нд Зэвсэглэлийн газар, Их Британийн БХЯ-нд Худалдан авалтын газар, Францын БХЯ-нд Зэвсэглэлийн асуудал эрхэлсэн комисс хариуцдаг байна. Үүнээс дүгнэлт хийж үзэхэд зэвсэгт хүчний нэгдэл, нэгтгэл, ангиудын ар тал болон техникийн хангалтыг материал-техникийн хангалт гэсэн нэгдсэн зохион байгуулалтад оруулж байгаа ажээ. “Зэвсэгт хүчний стратеги” (2017он) бүтээлд “Монгол Улсын

Зэвсэгт хүчинд материалын болон техникийн хангалтыг материал-техникийн хангалт гэсэн ар талын нэгдмэл тогтолцоонд шилжүүлж байна”[244.6] гэж онцлон тэмдэглэжээ.

“Зэвсэгт хүчний стратеги” номд “Цэргийн хангалтын систем /тогтолцоо/” гэсэн ойлголтыг:

- цэргийн нэгтгэл, анги, салбаруудын зохион байгуулалтын бүтэц, орон тооны бүрэлдэхүүн хэсэг, байлдааны талбарт цэргийн хангалтын үүрэг хүлээх шууд гүйцэтгэгч, дээд шатны хангалтын системийн хувьд дэд систем;

- цэргийн нэгтгэл, анги, салбаруудын материал-техникийн хангалтын байгуулалтын зүй тогтол болон зэвсэгт хүчний шинэчлэлийн нөхцөлд материал-техникийн хангалтыг зохион байгуулах тухай шинжлэх ухааны систем гэсэн хоёр хандлагаар авч үзэх болж байна.

Материал-техникийн хангалтын тогтолцоо нь тайван болон дайны цагт цэргийн (хүчний) материал-техникийн хангалтад зориулагдсан харилцан уялдаатай дэд тогтолцоо болон элементүүдийн *(цэргийн удирдлагын байгууллага, материал-техникийн хангалтын хүч хэрэгсэл)* цогц юм. Өөрөөр хэлбэл, улс орнуудын Зэвсэгт хүчний шат шатны бүтцэд байдаг цэргийн хангалтын тусгай хүч хэрэгслийг бүхэлд нь материал-техникийн хангалт бүрдүүлдэг байна.

“Материал-техникийн хангалт” нь тасралтгүй үйл явц юм.

Материал-техникийн хангалтыг байлдааны ажиллагаа (операц)-ны бэлтгэл болон явцад, цэргийн шилжилтийн үед, өдөр тутмын үйл ажиллагааны үед ч зохион байгуулж хэрэгжүүлдэг. Иймээс материал-техникийн хангалтын тогтолцоог байнга боловсронгуй болгон хөгжүүлэх хэрэгтэй болж байдаг. Үүний тулд цэргийн материал-техникийн хангалтын тогтолцооны бүрэлдэхүүн, боломж төдийгүй түүний хөгжлийн зүй тогтол, байлдааны нэгтгэл, анги, салбаруудтай харилцан ажиллах тогтвортой хандлага, аж ахуй хөтлөн явуулах эдийн засгийн шинэ нөхцөл, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулах журам, маркетинг ба менежментийн үндэс, дайны цагийн зах зээлийн эдийн засгийн бусад шинэ механизмыг мэдэх хэрэгтэй болно” [246.6] гэжээ. Ийнхүү оператив-стратегийн түвшний ар талын болон техникийн хангалт нь **нэгдмэл тогтолцоонд** шилжиж байгаа нь оператив-стратег, цэргийн хангалт үйлчилгээнд гарч байгаа бас нэг дэвшил билээ.

Материал-техникийн хангалтын тогтолцоо нь цэргийн албан үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс хангалтын систем нь хил хамгаалах болон оператив-стратег ажиллагааны

үндсэн тогтолцооны дэд тогтолцоо болох юм.

ОХУ-ын Цэргийн материал-техникийн хангалтын академид суралцах хугацаанд эрдэмтэн багш нарын заасан онолоор өнөөгийн цэргийн ар тал, техникийн хангалт нь Оператив-стратегии (Арми, корпус, нэгдэл)-ийн түвшинд “Материал-техникийн хангалт”, тактик (дивиз, бригад, хороо, батальон)-ийн түвшинд “Ар талын хангалт”, “Цэргийн аж ахуй” гэж нэршиж байна. Байлдааны ажиллагаа явуулж буй тактикийн түвшний нэгжид “Ар талын хангалт”, тайван цагт бэлтгэлд байгаа тактикийн нэгжид “Цэргийн аж ахуй”-г зохион байгуулдаг гэж үздэг. Хилийн цэргийн шугамын анги, салбар нь тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэдэг тул тактикийн нэгжийн хангалт нь “Ар талын хангалт”, бусад сургалт, хангалтын салбар, нэгжийн хангалт нь “Цэргийн аж ахуй” юм.

Хил хамгаалах ерөнхий газар нь оператив-стратегийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа тул зохион байгуулж байгаа хангалт нь “Материал-техникийн хангалт” гэж үзнэ.

Зориулалт, шийдвэрлэх үүргийн хувьд материал-техникийн хангалтын тогтолцоог:

2.1.материалын хангалт;

2.2.техникийн хангалт;

2.3.тээврийн хангалт;

2.4.цэргийн хүн эмнэлгийн хангалт;

2.5.мал эмнэлэг-эрүүл ахуйн хангалт;

2.6.зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн цэргийн нэгдэл, нэгтгэл, ангиудын материал-техникийн хангалтын тусгай төрөл гэсэн дэд системд ангилдаг байна” [246-247.6] хэмээн заажээ.

Үүнээс гадна бусад дэд тогтолцоонд гал түймрээс хамгаалахын хангалт, экологийн аюулгүй байдлын хангалт, материал-техникийн хангалтын анги, салбаруудын харуул хамгаалалт ба өнгөлөн далдлалт, материал-техникийн хангалтын удирдлагыг тус тус хамааруулж тооцно.

Цэргийн материал-техникийн хангалтын байгууллага (хүч хэрэгсэл)-ыг харьяаллын хувьд Зэвсэгт хүчинд: дивизийн, бригадын, хорооны, батальоны (дивизионы) ар тал техникийн хангалт, Хил хамгаалах байгууллагад: отрядын, комендатурын, заставын ар тал техникийн хангалт гэж ангилагдах бөгөөд тэр нь цэргийн материал-техникийн хангалтын бүтцэд онцгой байр эзэлнэ.

Хилийн цэргийн материал-техникийн хангалтын өнөөгийн байдал

Хилийн цэргийн материал-техникийн хангалт, хилийн анги, салбаруудын ар тал техникийн хангалт нь цэргийн бүх төрлийн хангалтын нэг үндсэн төрөл билээ.

Хилийн цэргийн материал-техникийн хангалтын өнөөгийн

байдлыг 2021-2024 оны байдлаар төрлөөр нь авч үзвэл:

Техник, тээвэр хангалт:

Хил хамгаалах байгууллага автопарк шинэчлэлийн хүрээнд улсын хил хамгаалалт, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологитой туулах чадвар сайжруулсан болон цахилгаан автомашин, газар уснаа явагч, мотоцикл зэрэг нийт 892 нэгж автомашин, техник шинээр авч, хил хамгаалалтад ашиглаж байна. Авто парк шинэчлэлт 44.5 хувь, үүнээс хилийн заставын автомашины шинэчлэл 100 хувь, цэрэг тээврийн автобусны шинэчлэлт 34 хувьд хүрсэн.

нөхцөлийг бүрдүүлж, тээврийн боломжийг 949 зорчигчоор буюу 37.7 хувиар нэмэгдүүлсэн.

Зорчигч тээврийн тоо: 126 багтаамж : 2513 зорчигч

Ачааны тээврийн хэрэгслийн тоо: 258 даац: 2653 тн байна.

Хилийн инженерийн хангалт:

Монгол Улсын хилийн хэсгийн инженерийн байгууламжаар халхлах боломжтой хэсгийг халхалсан хувь:

Хилийн торон саад – 45.4%

Мөр хянах зурвас – 28.5%

Шороон зурвас – 11.4%



Цэрэг тээврийн зориулалт бүхий 32 нэгж автобус худалдан авч хангаснаар бие бүрэлдэхүүнийг бүлэглэн шилжүүлэх, аюулгүй тээвэрлэх

Ойн зурвас – 10.2%

Нүхэн саад – 3% км

Монгол Улс-Оросын Холбооны Улсын хил хамтран шалгах ажлын хүрээнд нийт 1697 хилийн тэмдэг хүлээн авч, газар

дээр нь тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1073 км урт хилийн торон саад шинээр байгуулсан.

Хилийн цэргийн 7 ангийн хариуцсан хэсэгт 10 ширхэг хянах цамхаг шинээр байгуулсан.

Хилийн хэсэгт 7 ширхэг гүний худаг гаргаж, 6 ширхэг гүүр шинээр байгуулсан.

“Боршоо, Алтанбулаг” боомтын хэсэгт 125 км шилэн кабелийн дохиолол хяналтын систем байгуулах ажлыг гүйцэтгэсэн.

Хилийн цэргийн ангиудын хариуцсан хэсэгт 230 ком тоон радио релейн цамхаг байгуулсан.

Материал хангалт:

А.Барилга орон сууцны хангалт:

Байгууллагын хэмжээнд албаны байр 1294, орон сууц 686, харуулын байр 252, бусад зориулалтын 87 байр, нийт 2319 барилга ашиглагдаж байна.

Хил хамгаалах байгууллагын “Барилга байгууламжийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд УТХО-аар ХХЕГ-ын өргөтгөл, Эрээн цав, Цагаан-Уулын шинэ анги, Хилийн цэргийн 2 ангийн штаб, 1 ангийн соёлын төвийн барилгыг шинээр барьж, урсгал засварын зардлаар нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбогдсон. Хилийн цэргийн анги, салбаруудад 236 айлын орон сууц, штаб, гэрээт болон хугацаат цэргийн байр, эмнэлэг, агуулах

зэрэг 22 барилга, байгууламж барьж ашиглалтад оруулсан.

Хилийн цэргийн 3 салбар, 1 харуул, 2 сувиллыг шинээр төвлөрсөн эрчим хүчний системд холбож, 21 салбарт 5-10 кВт-ын нарны цахилгаан үүсгүүр суурилуулсан.

Хилийн цэргийн 3 ангийн төвийг төвлөрсөн дулаан хангамжид, 4 анги, 1 тусгай салбар, 57 хилийн салбарыг хийн халаалтад шилжүүлж, 10 ангийн төв, 53 хилийн салбарт бие даасан ариун цэврийн байгууламж суурилуулсан.

Б. Хүнсний хангалт:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан хилчдийн хүнсний хангамжийн 4 нормын дагуу хангалт зохион байгуулж байна. Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын хооллолтыг долоо хоногт 3 удаа сонголттой хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

Хилийн салбарын офицер, ахлагчийн хүнсний хангалтыг цахим захиалгаар 2024 онд хилийн цэргийн 0101 дүгээр ангид туршилтаар зохион байгуулж, 2025 оноос эхлэн улиралд 1 удаа зохион байгуулж байна.

Хилийн цэргийн ангиудад хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий хөргүүртэй машинаар хангах ажлыг зохион байгуулсан.

В. Хувцасны хангалт:

Хилийн шалган нэвтрүүлэх албаны зорчигчийн баримт бичиг шалгах манааны нэмэгдэл хувцас (пальто), цэргийн алба хаагчдын сэрүүний улирлын дулаан дотортой дээл, уулын болон ой тайгын бүсийн хилийн манааны урт түрийтэй өвлийн гутлын загвар, нормыг шинэчлэн ХЗДХЯ-ны сайдын 2022 оны А/147 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлиг /Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай/-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд шинэ төрөл загварын цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийг албаны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрэмбэлэн ангилж, нэн тэргүүнд хил хамгаалах байгууллагын хэмжээнд бүрэн олгох шаардлагатай 14 нэр төрлийн дүрэмт хувцас хэрэглэлийг бэлтгэж байна.

ХХЕГ-ын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар “Мөнгөн хангамжийн журам”-ыг батлуулан алба хаагчдад цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн хангалтыг мөнгөн хангамж хэлбэрээр олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Г.Хөдөө аж ахуйн хангалт:

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн мал, амьтдын тооллого зохион байгуулж, 52822 толгой амьтан тус тус тоологдсон.

Хилийн цэргийн ангиудад 209.1 сая төгрөгийн санхүүжилтээр мал, сүргийг

халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын эм, бэлдмэл, багаж, хэрэгсэл худалдан авч хангасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хил хамгаалах байгууллага “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, Хилийн цэргийн 0166, 0198, 0286, 0243, 0101-р анги, 0267-р тусгай салбарт Мод үржүүлгийн 6 агропарк, бусад ангиудад мод үржүүлгийн 23 төв байгуулж, 15 нэр төрлийн 1.5 сая ширхэг суулгац бэлтгэсэн.

Зэвсгийн хангалт:

Хил хамгаалах байгууллагад шаардлагатай 3 нэр төрлийн буудлагын зэвсэг, 374 нэгж галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, 4 нэр төрлийн ширхэг галт хэрэглэл, дуран харааны хэрэгсэл, 20 нэр төрлийн 1860 ширхэг тусгай хэрэгслийг худалдан авч, хилийн цэргийн анги, салбаруудад хангалтаар олгосон.

Хилийн цэргийн ангиудад засварын бүлэг томилон 20 ангийн буудлагын зэвсэгт их болон дунд засвар, үйлчилгээ хийсэн.

Нисэх алба:

Хил хамгаалах байгууллага Cessna 208B grand caravan EX бага оврын нисэх онгоц, Super puma EC225 загварын нисдэг тэргийг хил хамгаалалтад ашиглаж байна.

“Агаарын хөлгөөр гүйцэтгэх тусгай үүргийн нислэгийн захиалга авах, орлого

төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны А/111 тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна.

Хүн эмнэлгийн хангалт:

Хилийн цэргийн ангиудын Эрүүл мэндийн төвийг ЭМЯ-ны сайдын тушаалаар магадлан итгэмжлүүлж, магадлан итгэмжлэлд хамрагдсан 7 эрүүл мэндийн төвтэй болсон.

БНХАУ-ын Шанхай хотын “Тэнгисийн цэргийн анагаахын их сургууль”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Хөх хотын Анагаахын их сургууль” бусад мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 22 эмчийг хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

ХХЕГ-ын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар “Эрүүл биед саруул ухаан оршино” дунд хугацааны хөтөлбөр боловсруулан, баталгаажуулсан.

Материал-техникийн хангалтын цаашдын чиг хандлага

Олон улсын цэрэг, улс төрийн харилцаанд эрс өөрчлөлт гарч, хил дамнасан хориотой эд зүйлсийн хууль бус наймаа идэвхжин, мансууруулах бодис, хүний наймаа өргөжин тэлж, олон улсын хэмжээнд алан хядах ажиллагаа сүлжээ үүсгэж байгаа нь хил орчмын нөхцөл байдалд төвөгтэй байдлыг бий болгож буй тул улсын хилийн хамгаалалтын арга ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлт гарах хэмжээгээр Материал-техникийн хангалт, Ар тал, техникийн хангалтын онолыг

боловсронгуй болгон хөгжүүлэх, материал-техникийн хангалтын зохион байгуулалт, анги салбаруудын бүтэц бүрэлдэхүүн, боломж төдийгүй, хангалтын үйл ажиллагааны зүй тогтлыг сайжруулах шаардлага урган гарч байна.

Үүнээс гадна Монгол Улсын хөгжлийн стратеги бодлого нь бүсчилсэн байдлаар орон нутгийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд бүсчилсэн хил хамгаалалт, түүний материал-техникийн хангалтыг энэхүү бодлоготой нийцүүлэн зохион байгуулах нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй, илүү үр дүнтэй юм.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 33 дугаар зүйлд “Хилийн нөхцөл байдал, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт гэнэ. Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан хилчний хилийн нэмэгдэл, цалин, хангамж, материал хэрэгслийн хангалтын норм, хэмжээг Засгийн газар тогтооно...” гэж улсын хилийн бүсчлэн хамгаалалтыг зохион байгуулж явуулах эрх зүйн үндэс нь хуульчлагдсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын Засгийн газрын 2012 оны мн/110 дугаар тогтоолоор

батлагдсан “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрт Монгол Улсын хилийг газар орны онцлог, цаг агаар, хил хамгаалалтын онцлогоос шалтгаалан “Говь цөлийн”, “Тал хээрийн”, “Уулын”, “Ой тайгын”, “Төвийн” хэмээн таван бүст хуваасан билээ.

Улсын хилийн хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах үеийн энэхүү таван бүсийн материал-техникийн хангалт нь хилчдийн энерги зарцуулалт, газар орны бартаа саад, дэд бүтцийн хөгжил, зэвсэг техникийн ашиглалтаас шалтгаалан ялгавартай тогтоох, цаашид улсын хил хамгаалалт нь бүсчилсэн зарчмаар явагдах тул түүнд тохирсон бүсчилсэн хангалтыг зохион байгуулах бүтэц, удирдлагын тогтолцоо, хангалтын цувраажилт, хангалтын норм хэмжээг нарийвчлан тодорхойлох, шаардлагын дагуу үе шаттайгаар шинэчлэх талаар төлөвлөн ажиллаж байна.

Техник, тээвэр хангалт:

Бүс нутгийн газар зүйн онцлогт тохирсон автомашин, техникээр хилийн отряд, ангиудыг хангах.

Орчин үеийн туулах чадвар сайтай автомашинаар хилийн отряд ангийн тусгай томилгоот бүлгүүдийг хангах;

Цахилгаан автомашиныг төвийн бүсийн ангиуд, төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон хилийн анги, салбарт хангах;

UTV /4 дугуйт/ мотоциклоор хилийн салбаруудыг ханган

хилийн манааны үндсэн уналга болгох;

Хилийн цэргийн ангиудын дунд даацын ачааны автомашинуудыг шинэчлэх;

Усан хил хамгаалалтын техник хэрэгслүүдэд их засвар хийж, найдвартай байдлыг дээшлүүлэх;

Техникийн албан тушаалтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, жолооч бэлтгэх, ангилал ахиулах сургалтыг чанартай зохион байгуулан хүний нөөцийг бэхжүүлэх;

Шинэ загварын автомашин, техник, түүний ашиглалттай уялдуулан урсгал засвар, шатахууны төсвийг үе шаттай нэмэгдүүлэх;

Хилийн инженерийн хангалт:

Монгол Улс-Оросын Холбооны Улсын хил хамтран шалгах ажлын хүрээнд хилийн тэмдэг газар дээр нь байрлуулах ажлыг зохион байгуулах.

Улсын хилийн боломжит хэсгийг инженерийн торон саадаар бүрэн халхлах.

Хилийн зөрчил гарч болзошгүй хэсэг болон боомтын хэсэгт шилэн кабелийн дохиолол хяналтын систем байгуулах.

Хилийн цэргийн бүх ангийн хариуцсан хэсэгт тоон радио релейн цамхаг байгуулах.

Нисгэгчгүй нисэх хэрэгслээр хилийн цэргийн анги, салбарыг хангаж, хил хамгаалалтад ашиглах.

Материал хангалт:

А.Барилга орон сууцны хангалт:

“Барилга байгууламжийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд хилийн цэргийн 2 анги шинээр байгуулж, ангийн төвд 825, хилийн салбарт 685 айлын орон сууц, штаб, соёл, спортын цогцолбор, хүн эмнэлэг, агуулах бусад зориулалтын 156 барилга шинээр барих;

Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр анги, тусгай салбарын 7, салбаруудын 36 хувийг төвлөрсөн эрчим хүчний системд холбох, 27 хувийг 10 кВт-ын нарны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 40 хүртэл кВт болгох;

Дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд анги, тусгай салбарын 26 хувийг, салбаруудын 7 хувийг суурьшлын газрын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох;

Байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон түлшний зарцуулалт багатай хатуу болон шингэн, хийн түлшний халаалтын зуухыг анги, салбаруудын дулаан хангамжид нэвтрүүлэх;

Б. Хүнсний хангалт:

Хилийн цэргийн хүнсний хангалтын зааврыг шинэчлэн боловсруулах.

Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын хүнсний тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх ажлыг зохион байгуулах.

Хүнсний цахим захиалгын программыг ашиглалтад оруулж, хилийн салбарын офицер, ахлагчийн хүнсний хангалтыг захиалгаар хүргэх ажлыг хэвшүүлэх.

В. Хувцасны хангалт:

“Мөнгөн хангамжийн журам”-ыг хэрэгжүүлэн алба хаагчдад цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн хангалтыг мөнгөн хангамж хэлбэрээр олгох.

Хилийн цэргийн анги, салбаруудыг шинэ загварын хувцсаар бүрэн хангах ажлыг зохион байгуулах.

Бүсчилсэн хил хамгаалалтын хүрээнд байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэдэг Хилчдийн цэргийн дүрэмт хувцас хэрэглэлд орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэд “Халдаг хувцасны технологи”-ийг албанд нэвтрүүлэх.

Г.Хөдөө аж ахуйн хангалт:

Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бөгөөд эхний ээлжид зүүн бүсийн эрчимжсэн аж ахуй цогцолборыг байгуулж таваарлаг мал, амьтдыг өсгөн махны гарцыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хилийн цэргийн 27 ангид хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

Хил хамгаалах байгууллагын “Ногоон хэрэм” төслийг хэрэгжүүлж, хилийн цэргийн анги, тусгай салбарын агропарк, мод үржүүлгийн төвийн ажлыг эрчимжүүлэх.

Зэвсгийн хангалт:

Хилийн цэргийн анги, боомтуудын тусгай томилгоот бүлгүүдийн зэвсэглэл, тусгай хэрэгслийн хангалтыг эхний ээлжид цаашид хилийн салбарын зэвсэглэл, тусгай хэрэгслийн хангалтыг үе шаттай шинэчлэх ажлыг зохион байгуулна.

Хүн эмнэлгийн хангалт:

ХХЕГ-ын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар “Эрүүл биед саруул ухаан оршино” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хилчдийн эрүүл ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Өмнөд, баруун, зүүн, хойд бүсүүдэд бага оврын нисдэг тэрэгтэй нисэх хэсэг байгуулах.

Дүгнэлт

Улсын хил хамгаалалтын өнөөгийн материал техникийн хангалт зохих түвшинд байгаа боловч олон улсын цэрэг, улс төрийн хурцадмал нөхцөл, бүсчилсэн хил хамгаалалтад шилжих зэргээс улсын хилийн хамгаалалтын арга ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлт гарах хэмжээгээр Материал-техникийн хангалт, Ар тал, техникийн хангалтын онолыг боловсронгуй болгон хөгжүүлэх, материал-техникийн хангалтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, анги

Хилийн ангиудын эрүүл мэндийн төвүүдийг магадлан итгэмжлэлд оруулж, эмнэлгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах.

Хилчдийн зонхилох өвчний судалгааг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, сувилгааг бүсчилсэн байдлаар зохион байгуулах.

Нисэх алба:

Нисдэг тэрэгний тоог нэмэгдүүлэн, нисэх хэсгийг өргөтгөн хилийн цэргийн нисэх ангийг дахин байгуулж, хил хамгаалалтад агаарын хөлгийг тогтмол ашиглах.

Агаарын хөлгийн ангар шинээр байгуулж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, нисэхийн газрын төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ авах.

салбаруудын бүтэц бүрэлдэхүүн, боломж төдийгүй, хангалтын үйл ажиллагааны зүй тогтлыг сайжруулах нь улсын хилийн аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадварын суурь бүрэлдэхүүн болно гэж дүгнэж байна.

Дээрх дүгнэлтээс үндэслэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1.Бүсчилсэн хил хамгаалалтын хүрээнд стратеги, оператив, тактикийн түвшинд бүсчилсэн хангалт зохион байгуулах судалгаа шинжилгээ хийх.

2.Бүсчилсэн хил хамгаалалтын материал-техникийн хангалтыг улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах арга замыг тодорхойлох.

3.Материал-техникийн хангалтын тогтолцоог шинэчлэн бүсийн хилийг удирдах газрын дэргэд бүсийн хангалтын төвүүдийг байгуулах талаар тооцоолол хийх.

4.Бүсчилсэн хангалтын цувраажилт, нөөц бүрдүүлэлтийн асуудлыг тодорхойлох зэрэг саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалж:

- 1.“Зэвсэгт хүчний стратеги” 2017 он
 - 2.Ар талын дүрэм. УБ. 2017
 - 3.Ганбаатар.Д “Системийн онолыг хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн материал техникийн хангалтад ашиглах нь” УБ.2019.
 - 4.Батбаатар.Б., Намнан.Ж. Цэргийн ар талын удирдлага,төлөвлөлт УБ.2008
- Цахим эх сурвалж:
- 5.Vamto.mil.ru